

**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**Өргөн сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Аудитын код: ДГА-2019/10/СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд хот 2019 он	Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа	
	Утас: 70522734	Цахим хаяг: Dornogovi@audit.gov.mn
	Аудитын менежер: Ц.Лүндэгмаа	
	Утас: 70523020	Цахим хаяг: Lundegmaa.Ts@audit.gov.mn
	Аудитор: О.Нарангарав	
	Утас: 70523020	Цахим хаяг: Narangarav.O@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан.....	5
2.1.	Оршил.....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.8.1	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар	9
2.8.2	Төсвийн төвлөрүүлэн захирагчын шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар	10
2.8.2.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	11
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..	12
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	12
2.11.	Шилэн дансны мэдээлэл	13
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	14
2.13.	Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:.....	14
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	14
3.	Аудит хийсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	16
3.1	Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН.....	16
3.2	Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН	18
3.3	Аудит хийсэн МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	21
3.4	Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	24
3.5	Аудит хийсэн ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН	25

1 Аудитын гэрчилгээ



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

2019.03.20 № 1-6/338

танай _____ -ны № _____ -т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ӨРГӨН СУМЫН ЗАСАГ ДАРГА
Ж.СҮХБААТАР ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Өргөн сумын Төвлөрүүлэн захирагчийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Өргөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Өргөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Өргөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа төсвийн шууд захирагчийн 6 байгууллага, 3 сангийн санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөрчилгүй, 1 хязгаарлалттай, 1 санал дүгнэлт өгөхөөс татгалзсан санал дүгнэлт авсан байна. 1 байгууллага 3 сан түүврийн аудитад хамрагдсан.

Сумын Засаг даргын Тамгын газар 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн тайлангаа хуулийн хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй нь цаг хугацааны хязгаарлалтад оруулж санал дүгнэлт өгөхөөс татгалзсан. Засаг даргын Тамгын газрын 2018 оны төсвийн нийт гүйцэтгэл 300.1 сая төгрөг буюу Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн нийт гүйцэтгэл /1,392.7 сая төгрөг/-ийн 21.5 хувийг эзэлж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн алдаа зөрчил нь аудитын гүйцэтгэлийн үе шатанд тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан нь санхүүгийн тайлангийн үнэн зөв, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байх тул хязгаарлалттай санал дүгнэлт авсан.

Тус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд материаллаг байдлын түвшинг 49.7 сая төгрөгөөр тогтоосон. Төсвийн шууд захирагчдын тайланд илэрсэн зөрчил нь 70.3 сая төгрөг буюу бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс 1.4 дахин давсан байна.

Үүрэг, хариуцлага

Өргөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Өргөн сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч сумын Засаг дарга Ж.Сүхбаатар-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Өргөн сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өргөн сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.03.07-наас 2019.03.14.-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.03.15.-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-ын О.Нарангарав хариуцаж хэрэгжүүлэв.

Өргөн сумын Засаг дарга 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар-т 2019.03.05-ны өдрийн 5/94 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Өргөн сумын Засаг даргын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Өргөн сумын Засаг дарга нь “Засгийн газраас эрх нь шилжиж ирсэн зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх, сум, байгууллагын үйл ажиллагааг оновчтой төлөвлөж хэрэгжүүлэх, ажлын байрны шаардлагад нийцүүлэн мэдлэг чадвараа дээшлүүлэх, төрийн албаны тухай хууль тогтоомж, стандарт, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах, үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, төсөв болон эд хөрөнгийг зохистой ашиглах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, төсвийн захирагчийн тухайн жилд гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлоход оршино” гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Аймгийн Засаг даргатай байгуулсан 2018 оны үр дүнгийн гэрээнд Өргөн сумын Засаг даргын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Нийтийн албаны бодлого
2. Хяналт шинжилгээ, мэдээлэл боловсруулалт
3. Хууль зүйн салбарын нийлүүлэх ажил үйлчилгээ
4. Батлан хамгаалах ажил үйлчилгээ
5. Гамшгаас урьдчилан сэргийлэх ажил үйлчилгээ

6. Санхүү, төрийн сангийн ажил үйлчилгээ
7. Худалдан авах ажиллагаа
8. Нийгмийн салбарын ажил үйлчилгээ
9. Үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтэц, газрын харилцаа, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын чиглэлийн ажил үйлчилгээ

Өргөн сумын Засаг дарга удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хууль
- Засгийн газрын тогтоол, шийдвэрүүд
- Сангийн сайд болон бусад сайдын тушаал шийдвэрүүд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 10 байгууллага, нэгж 2018 оны санхүүгийн тайландаа аудит хийж баталгаажуулахаас 6 байгууллага аудитад хамрагдсан байна.

Төрийн аудитын байгууллагаас Өргөн сумын Засаг даргын эрх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр				
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрлэсэн	Итгэл үзүүлсэн	Гэрээгээр хийлгэсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	5	1	-	-	-
2	Төсвийн төвлөрүүлэн захирагч	1	3	-	-	-
Дүн		6	4	-	-	-

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Өргөн сумын Засаг даргын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Өргөн сумын Засаг даргын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг үнэлэхэд шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Өргөн сумын Засаг дарга дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Өргөн сумын Засаг даргын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 11 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 11 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийн 1 хувиар сонгов.

Нийт хөрөнгийг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь нийт орлого, зарлагын дүнгээс их байгаатай холбоотой юм.

Өргөн сумын Засаг даргын 2018 оны нийт хөрөнгө 4,973.3 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 49.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь эрсдлийн түвшинг дунд гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн материаллаг биш боловч цаашид санхүүгийн тайлан, тодруулгад материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй зарим асуудлыг толилуулж байна.

Өргөн сумын Засаг дарга болон төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагчийн хэмжээнд 72.2 сая төгрөгийн, төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэмжээнд 78.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 80.6 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулав.

Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлыг хэрхэн ангилж, шийдвэрлэсэн байдлыг энэ тайлангийн 2.13-т нэгтгэсэн байдлаар үзүүлэв.

Асуудлыг өмнөх түвшинд хийсэн аудитын явцад гарсан асуудал, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад түүвэрт хамрагдсан асуудлаас илэрсэн асуудал гэсэн ангиллаар үзүүлэв.Үүнд:

2.8.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

Асуудал 1: Балансын данстай холбоотой

Өргөн сумын ЕБС-ийн бохирын шугамын засварын ажлыг ажил гүйцэтгэх гэрээ байгуулан, ажил бүрэн хэрэгжээгүй байхад төлбөрийг бүрэн шилжүүлэн 19.0 сая төгрөгөөр авлага үүсгэн бүртгэсэн байна.

Шийдэл:

Авлага үүсгэсэн төлбөрт албан шаардлага өгсөн.

Асуудал 2: Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт

Өргөн сумын ЕБС тайлант хугацаанд урсгал засварын зардалд 30.3 сая төгрөг, хичээл үйлдвэрлэлийн зардалд 18.6 сая төгрөгийн төсөв батлуулан зарцуулалт хийхдээ шууд худалдан авалт хийж хууль зөрчсөн байна.

Шийдэл:

Алдаа зөрчилд албан шаардлага өгсөн.

Асуудал 3: Төсвийн өмнө хүлээсэн биелэлт

Өргөн сумын төсөвт байгууллагууд санхүүгийн тайланг хугацаа хоцроож аудитын байгууллагуудад ирүүлж төсвийн тухай хууль зөрчсөн байна.

Шийдэл:

Нэг байгууллагад Зөвлөмж өгч, нэг байгууллагад дүгнэлт өгөхөөс татгалзсан болно.

Асуудал 4: Анхан шатны баримт бүрдэлттэй холбоотой

Авлага, өр төлбөрийг баталгаажуулаагүй, барагдуулаагүй, мөн анхан шатны баримт бүртдэл дутуу баримтаар гүйлгээг хийсэн, тайлагнасан байна.

Шийдэл:

Аудитаар байгууллагуудад зөвлөмж өгсөн.

2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчын шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 11 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 9 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

№	Залруулгын товч утга	Мөнгөн дүн (мянган төгрөгөөр)	Үүнээс: Залруулгын ангилал			
			Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлттэй холбоотой	Тайлант хугацаанд гарсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа	Өмнөх тайлант хугацаанд гарсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа	Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлттэй холбоотой
1	Санхүүгийн тайлангийн нэгтгэл хийхдээ Нэмэлт данс болон төвлөрүүлэн шилжүүлэгийг тохируулаагүй байна.	9,591.4		9,591.4		
2	Үр дүн болон мөнгөн гүйлгээний тайланд Нэмэлт санхүүжилтийн дансны орлогыг туслах үйл ажиллагааны орлогод бүртгэн тайлагнаж залруулгыг дутуу хийсэн байна.	1,500.0		1,500.0		
3	Аймгаас авсан санхүүгийн дэмжлэгийг дутуу бүртгэсэн байна.	5,239.9		5,239.9		
Дүн		16,331.3		16,331.3		

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	0	0.00	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	0	0.00	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.2.1.1 Орлогын данстай холбоотой асуудал

Аймгаас авсан санхүүгийн дэмжлэгийг 5.2 сая төгрөгөөр дутуу тайлагнан бүртгэсэн байна.

Энэ нь Үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Шийдвэрлэсэн: Аудитын явцад залруулан бүртгэсэн.

2.8.2.1.2 Балансын данстай холбоотой асуудал

Санхүүгийн тайлангийн нэгтгэл хийхдээ нэмэлт данс болон төвлөрүүлэх шилжүүлгийн зардлын 9.6 сая төгрөгийг тохируулаагүй байна.

Энэ нь Үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Шийдвэрлэсэн: Аудитын явцад залруулан бүртгэсэн.

2.8.2.1.3 Балансын данстай холбоотой асуудал

Үр дүн болон мөнгөн гүйлгээний тайланд Нэмэлт санхүүжилтийн дансны 1.5 сая төгрөгийн орлогыг туслах үйл ажиллагааны орлогод бүртгэн тайлагнаж залруулгыг дутуу хийсэн байна.

Энэ нь Үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:

Шийдвэрлэсэн: Аудитын явцад залруулан бүртгэсэн.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Өргөн сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Өргөн сумын Засаг даргын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 9 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 1,441.0 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн орлогын нийт гүйцэтгэл 1,428.6 сая төгрөг буюу 99.1 хувь, зардлын нийт гүйцэтгэл 1,392.7 сая төгрөг буюу 96.6 хувьтай байгаа нь төсөвт байгууллагуудын бараа үйлчилгээний зардал хэмнэлттэй гарсан нь шалтгаалжээ.

Татварын орлогын биелэлт 330.7 сая төгрөг буюу 80.3 хувьтай, 81.2 сая төгрөгөөр тасарсан байна. Орлого тасрахад дараах нөхцөл байдлыг:

- Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр хураамжийг суманд үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж байгууллагуудтай аймгийн Засаг дарга гэрээ байгуулж орлогын төлөвлөгөөг 346.9 сая төгрөгөөр тодотгон сумын ИТХ-аар батлуулсан. Аж ахуй нэгжүүд гэрээний үнийн дүндээ үйл ажиллагаа явуулаагүй, хийгдсэн ажлын хүрээнд орлого төвлөрүүлсэн тул орлогын төлөвлөгөөний биелэлт 81.6 сая төгрөгөөр тасрах шалтгаан болсон.
- Хог хаягдлын хураамжийн орлого 3.7 сая төгрөгөөр тасарсан нь хог зөөврийн машин удаа дараа эвдэрч, иргэд хог зөөвөрлөсний хураамж гэж ойлгодогтой холбоотой хураамжийг төлөөгөйтэй гэсэн тайлбараар тайланд ирүүлсэн.

Сумын татварын орлогыг 411.8 сая төгрөгөөр татварын бус орлогыг 4.6 сая төгрөгөөр нийт орлогыг 416.4 сая төгрөгөөр баталсан байна. Тусгай шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилт 971.0 сая төгрөг, ОНХСангийн санхүүжилт 82.0 сая төгрөгөөр, аймгийн төсвөөс санхүүжих 11.6 сая төгрөгөөр нийт төсвийн орлогыг 1,399.0 сая төгрөгөөр баталсан байна.

Сумын ИТХ-ын санхүүжилт 41.3 сая төгрөгөөр, ЗДТГазар 304.7 сая төгрөг ОНХСан 82.0 сая төгрөгөөр, тусгай шилжүүлгийн байгууллагын шилжүүлэг 971.0 сая төгрөгөөр нийт төсвийн зарлагыг 1,399.0 сая төгрөгөөр баталсан байна.

Нөхөн сэргээлтийн сангийн орлого зарлагыг 13.5 сая төгрөгөөр, Сум хөгжүүлэх сангийн орлого, зарлагыг 28.5 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Татварын болон татварын бус орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь авч үзвэл:

		Төлөвлөгөө / мян.төг/	Гүйцэтгэл /мян.төг/	Зөрүү /дутуу + , илүү - /	Хувь
1	ХХОАТ	11,730.00	16,959.61	(5,229.61)	144.6
	Үйл ажиллагааны орлогын татвар	2,020.00	3,610.31	(1,590.31)	178.7
	Бусад орлогын татвар	9,710.00	13,349.30	(3,639.30)	137.5
2	Бууны татвар	1,890.00	1,862.00	28.00	98.5
3	УТХураамж	1,410.00	1,593.86	(183.86)	113.0
4	Хог хаягдлын хураамж	8,334.00	4,646.00	3,688.00	55.7
5	ТТАМАТөлбөр	346,900.00	265,300.00	81,600.00	76.5
6	Бусад орлого /хүү /	11,670.00	9,873.03	1,796.97	84.6
7	Бусад орлого/ торгууль/	100.00	50.00	50.00	50.0
8	ҮХХ борлуулсны орлого	2,400.00	2,895.10	(495.10)	120.6
9	Төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого	4,500.00	5,073.73	(573.73)	112.8
10	Агнуурын нөөц ашиг/төлбөр, ан амьтан агнах барих зөв/хураамж	27,515.00	27,515.04	(0.04)	100.0
	Дүн	416,449.00	335,768.36	80,680.64	80.6

Сумын ИТХ болон ЗДТГ-ын төсвийн гүйцэтгэл 341.4 сая төгрөг буюу 99.2 хувьтай, тусгай шилжүүлгийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл 967.8 сая төгрөг буюу 99.7 хувьтай байна.

Аймгаас 10.9 сая төгрөгийн татаас санхүүжилт авч, сумын ЗДТГ, ИТХ-ын зарцуулаагүй үлдэгдэл 5.2 сая төгрөгийг аймгийн төсөв, тусгай шилжүүлгийн байгууллагын төсвийн хэмнэлт 3.2 сая төгрөгийг улсын төсөвт тус тус татан төвлөрүүлж, нэмэлт дансны зарцуулагдаагүй үлдэгдэл 2.6 сая төгрөгийг авлагаар бүртгэж сумын орлогод төвлөрүүлсэн байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Өргөн сумын Засаг дарга Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж байхгүй болно.

2.13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Өргөн сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт илэрсэн алдаа, зөрчлийн 53.4 хувь буюу 80.4 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 0.3 хувь буюу 405.2 мянган төгрөгийн зөрчилд хохирлыг барагдуулах төлбөрийн акт тогтоож, 45.1 хувь буюу 68.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 1.2 хувь буюу 1.9 сая төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүллээ.

Төрийн аудитын байгууллагаас аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил түүний шийдвэрлэлийн байдлыг дор нэгтгэн үзүүлэв. Үүнд:

№	Байгууллагын ангилал	Илрүүлэлт						Залруулга	
		Зөрчил		Алдаа		Бүгд дүн		Тоо	Дүн
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	ТТЗ	0	0.0	5	78.7	5	78.7	5	78.7
2	ТШЗ	14	70.3	1	1.9	15	72.2	1	1.9
3	ТБӨААН	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0
	Дүн	14	70.3	6	80.6	20	150.9	5	80.6

Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

(сая төгрөг)

Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТТЗ	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0
2	ТШЗ	14	70.3	1	0.4	2	68.0	10	1.9	1	0.0		
3	ТБӨААН	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0
	Дүн	14	70.3	1	0.4	2	68.0	10	1.9	1	0.0	0	0.0

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Өргөн сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Өргөн сумын Засаг даргын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

Санал дүгнэлтийн хэлбэр (Тоогоор)

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлтийн хэлбэр (Тоогоор)				Дүн
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан	
1	ТШЗ	3	1	0	1	5
2	ТТЗ	0	1	0	0	1
	Дүн	3	2	0	1	6

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3. Аудит хийсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН

3.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	514,812,440.15	490,788,078.49
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	46,805,667.00	82,733,546.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	46,805,667.00	82,733,546.00
31210	Төгрөг	46,805,667.00	82,733,546.00
31211	Төрийн сангийн харилцах	46,805,667.00	82,733,546.00
33	АВЛАГА	257,964,465.00	174,750,447.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	200,000.00	203,159.00
33500	Бусад авлага	101,376,864.00	54,186,660.00
33510	Байгууллагаас авах авлага	95,369,901.00	51,549,297.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	6,006,963.00	2,637,363.00
33600	Зээлийн авлага	156,387,601.00	120,360,628.00
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	156,387,601.00	120,360,628.00
33612	Хувь хүмүүст олгосон зээл	156,387,601.00	120,360,628.00
35	БАРАА МАТЕРИАЛ	210,042,308.15	233,304,085.49
35100	Түүхий эд материал	33,146,008.38	36,713,286.72
35110	Тусгай зориулалттай материал	30,408,549.56	32,749,477.56
35130	Эм боох материал	2,737,458.82	3,963,809.16
35400	Хангамжийн материал	118,986,099.77	137,852,758.77
35410	Бичиг хэргийн материал	1,549,398.00	2,484,304.00
35420	Аж ахуйн материал	107,331,803.77	123,533,568.77
35430	Сэлбэг хэрэгсэл	216,500.00	339,900.00
35440	Түлш, шатах тослох материал	785,440.00	1,425,600.00
35450	Барилгын засварын материал	0	655,120.00
35460	Хүнсний материал	6,233,471.00	6,436,279.00
35470	Бусад хангамжийн материал	2,869,487.00	2,977,987.00
35600	Мал амьтад	57,910,200.00	58,738,040.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,754,218,972.59	4,482,534,928.70
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,754,218,972.59	4,482,534,928.70
39200	Биет хөрөнгө	3,753,789,014.38	4,362,221,470.57
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,625,628,119.00	3,585,782,126.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-776,959,040.84	-52,422,371.32
39203	Авто-тээврийн хэрэгсэл	353,941,043.00	345,670,543.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-231,430,439.37	-257,963,801.69
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	245,511,839.29	292,982,895.29
39206	Хуримтлагдсан элэгдэл	-166,252,345.07	-190,968,012.83
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	188,922,413.27	186,243,404.35
